



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 01 сарын 04 өдөр

Дугаар А/03

Мөрөн сум

Газар эзэмших эрхийн гэрчилгээ
шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1, 38.4, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2, 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Иргэн Отгой овогтой Баянмөнх /РИ80030410/-ийн хүсэлтийн дагуу Мөрөн сум 13 дугаар баг 26а-4 тоотод байршилтай 6712015954 нэгж талбарын дугаартай 1052м² гэр бүлийн хэрэгцээний зориулалттай газрыг иргэн Гүррагчаа овогтой Батбаатар /РЕ74091175/-т 581м² газрыг 31 жилийн хугацаатайгаар шилжүүлэн эзэмшүүлж, үлдсэн 471м² газрыг О.Баянмөнхөд гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар 31 жилийн хугацаагаар үргэлжлүүлэн эзэмшүүлсүгэй.

2. Уг захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2020 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн А/278 дугаар захирамжийн хавсралтын 13 дахь мөрийг хүчингүй болгосугай.

3. Захирамжаар газар эзэмшигч Г.Батбаатар, О.Баянмөнх нартай тус тус газар эзэмших эрх зүйн баталгаажилт хийж, Улсын бүртгэлд бүртгэхийг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Б.Ганзориг), Улсын бүртгэлийн хэлтсийн дарга (Б.Эрдэнэбилэг) нарт зөвшөөрсүгэй.

4. Аймгийн Засаг даргын захирамжийг эс зөвшөөрвөл захирамжийг мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор аймгийн Засаг даргад гомдол гаргах эрхтэй болохыг дурдсугай.

5. Захиргааны актыг ажлын 5 хоногийн дотор эрх, ашиг сонирхол хөндөгдөж буй этгээдэд мэдэгдэж, баримтжуулсан захиргааны актыг хувийн хэрэгт бүрдүүлэлт хийж ажиллахыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Б.Ганзориг)-д үүрэг болгосугай.

6. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс (Х.Цэнд-Аюуш), Мэргэжлийн хяналтын газрын дарга (Д.Түмэнбаяр) нарт үүрэг болгосугай.

ДАРГА

Ш.ИДЭРБАЯСГАЛАН